

**БАЙГАЛИЙН ГАМШИГТ ҮЗЭГДЛИЙН ҮЕИЙН ЖЕНДЭРТ СУУРИЛСАН
ХҮЧИРХИЙЛЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ
(ЗУДЫН ҮЕИЙН ЖИШЭЭН ДЭЭР)**

*Н.Болдмаа доктор, дэд профессор
МУИС-ийн ШУС, Социологи, нийгмийн ажлын тэнхим
ORCID: 0000-0003-3985-9923*

*Т.Бүрэнжаргал
МУИС-ийн Социологи, нийгмийн ажлын тэнхим профессор
ORCID: 0000-0003-3985-9923*

*С.Золзаяа
Жендэр судлалын магистрант*

Abstract: *Mongolia is an extremely susceptible country to climatic change due to its isolated geographical location, vulnerable ecosystem, and economic system dependent on nature and climate. Within the period of the last 40 years, the ecosystem of Mongolia has undergone a significant change due to global climatic change and human activities, and thus is being threatened by desertification, an increase of repeated drought and dzud, water resource issues, and scarcity of diverse biological species. As members of socially vulnerable groups are susceptible to violence during catastrophes, the issue of protecting them is emphasized globally. This study aimed to identify herders' perceptions and attitudes towards gender-based violence, and the types of gender-based violence that herders are exposed to during the dzud. Within the scope of the same objectives, researcher performed the data collection of the assessment from within 14 soums of seven aimags (Bayan-Ulgii, Khovd, Gobi-Altai, Uvs, Zavkhan, Khentii, and Khuvsgul). When dzud-affected herders were asked about their understanding of GBV, the majority (79.8%) had never heard of the term “GBV” before or only heard it but with no understanding of the term GBV. Some negative impacts arose in the demand for mental, physical, financial, and other fundamental necessities during dzud. In the mental state of herders during dzud, 13.6% were anxious and fearful. A total of 61 herders (15.9% of all herders) were exposed to some type of violence during dzud.*

Key words: *climate change, during the dzud, gender based violence, domestic violence, herders.*

Оршил

Эх газрын хуурай, эрс тэс уур амьсгалтай, жилийн дөрвөн улиралтай, Евроазийн төвд байрладаг онцлог байдлаас шалтгаалан Монгол оронд уур амьсгалын өөрчлөлт хурдацтай, дэлхийн дунджаас 2 дахин их явагдаж байгаа бөгөөд сүүлийн 80 гаруй жилд гадарга орчмын агаарын дундаж температур 2.46°C градусаар нэмэгдэн эрчимжсэн байна (Ministry of Environment and Tourism of Mongolia, GEF and UNEP, April, 2024). 2024 оны байдлаар жилийн дундаж агаарын температур 1.9°C буюу 1940 оноос хойших 2 дахь дулаан жил болсон (Ус цаг уур орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн, 2024). Ингэснээр уур амьсгалын өөрчлөлт явагдаж байгалийн гамшигт үзэгдлүүд болох ган, зуд, салхи, шуурга, үер усны давтамж нэмэгдэж, нийт газар нутгийн 76.9 хувь нь цөлжилтөд өртөж, бэлчээрийн доройтол, усны хомсдол хурдацтай явагдаж байна (Ministry of Environment and Tourism of Mongolia, GEF and UNEP,

April, 2024). Монгол Улс уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд өртөмтгий байдлын үнэлгээгээр 2023 оны ND-GAIN индексээр 181 орноос 54-д жагсаж байна (University of Notre Dame, 2023).

Энэхүү уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн төлөв байдлын өөрчлөлт нь дотоодын нийт бүтээгдэхүүний 10.5 хувь, ажиллах хүчний 21.6 хувийг бүрдүүлж байгаа (Хүнсний хувьсгал үндэсний хөдөлгөөн, 2024) мал аж ахуйн салбарт сөрөг үр дагавар бий болгож байна. Монгол банкны панел регрессийн шинжилгээгээр температур 1 градусаар нэмэгдэх нь Монгол улсын ДНБ-ий өсөлтийг 0.48 хувиар сааруулдаг гэжээ (Л.Даваажаргал, Б.Ананд, Э.Хосбаяр, 2023). Нийт хүн амын 19.4 хувь буюу таван хүн тутмын нэг нь малчин өрхөд амьдарч, ажиллах хүчний 26.7 (дөрвөн хүн тутмын нэг) хувийг малчид бүрдүүлж, нийт өрхийн 25.8 хувийг малтай өрх, үүний 73.5 хувийг малчин өрх эзэлж байна (МУ-ын Засгийн газар, Монгол малчин Үндэсний хөтөлбөр, 2020). 1944 оноос хойш хийсэн судалгаагаар манай оронд болсон зудын нөлөөгөөр нэг жилийн дотор ихдээ 9, багадаа 1 сая орчим толгой мал хорогдож байсан ба энэ нь тухайн жилд тоологдсон нийт малын тооны 2-33 хувийг эзэлж байв. Сүүлийн 30 жилд гэхэд л нийт 21.1 сая толгой мал хорогдож, 860 тэрбум төгрөгийн хохирол учирчээ. Цаашид илүү хатуу ширүүн зуд болж, 2050 он гэхэд зудын улмаас жилд дунджаар 4.1 сая (нийт мал сүргийн 5.8 хувь), 2100 он гэхэд 6.8 сая (нийт мал сүргийн 9.6 хувь) мал сүрэг хорогдох магадлалтай байна (Дэлхийн банк, 2024). Хүйтэн, халуун өдрийн тоо нэмэгдэх, хэт халалт, хүйтрэл, ширүүн бороо, хуй салхи гэх мэт үзэгдлийн тоо нэмэгдэж байгаа, 2024 онд Баянхонгорын Эхийн голд агаарт 40.8°C, Сүхбаатар аймгийн Баяндэлгэрт хөрсөн дээр 71°C хүрч халсан бол Завханы Отгон суманд агаарт -48.8°C, хөрсөн дээр -50°C хүрч хүйтэрсэн байна (Ус цаг уур орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн, 2024).

Ингэснээр малчид, иргэдийн уламжлалт амьдралын хэв маяг алдагдаж, мал маллагаа, цаашлаад малчдын эдийн засгийн нөхцөл байдал тогтворгүй болж, жендэрийн тэгш бус байдал гүнзгийрэн илүү нарийн төвөгтэй жендэрийн олон талт асуудлуудтай тулгарах төлөв ажиглагдаж байна. Мал маллахад байгаль, цаг уураас шалтгаалсан хүндрэл хамгийн том бэрхшээл болж байгаа, тухайлбал, нийт судалгаанд оролцогчдын 95.8 хувь нь ган гачиг, 90.3 хувь нь зуд турхан, 90.4 хувь нь бэлчээрийн хомсдол, 80.9 хувь нь гол горхи булаг шанд хатах ширгэх, усны хомсдол үүсдэг гэжээ (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт, 2018). Мөн 2024 онд улсын хэмжээнд 104 удаагийн цаг агаарын гаралтай аюулт болон гамшигт үзэгдэл болсноос аюултай үзэгдэл 95 удаа, гамшигт үзэгдэл 13 удаа болж үүний улмаас 3 хүн амь насаа алдаж, 3,058,998 толгой мал хорогдож, улс нийгэмд 3 тэрбум 27 сая 313 мянга 260 төгрөгийн шууд хохирол учирсан. (Ус цаг уур орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн, 2024).

НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын Үндэсний гуравдугаар тайлан-илтгэлд, эмзэг байдлын үнэлгээгээр уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнөөс бий болох байгалийн аюулт, гамшигт үзэгдлийн эрсдэл, түүний нүүрлэх нийт хувь хэмжээ 2046-2065 он хүртэл нийт газар нутаг, дийлэнх аймгийн хэмжээнд өсөх хандлагатай гэж тодорхойлсон. Түүнчлэн, агаарын хэмийн өсөлт зэрэг хүчин зүйлсийн улмаас хэт халалт, ган гачигтай өдрийн тоо нэмэгдэх хандлагатай байгаа нь зудын давтамж ихсэж, эрч нь ширүүсэхээр төлөвтэй байна. Уг судалгаагаар хүүхэд, эмэгтэйчүүд, малчид зэрэг эмзэг бүлгийнхэн уур амьсгалын нөлөөлөлд өртөх өндөр эрсдэлтэй байгааг онцолжээ (USAID, 2017). Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд дан ганц эмэгтэйчүүд эмзэг биш, өвөлжилт хүнд нөхцөлд эрэгтэйчүүдэд бас их нөлөөлдөг. Ялангуяа, малчид отроор явах үед гэр бүл олон сар тусдаа байх, хичээл сургуулийн үед эхнэр, хүүхдүүд сумын төвд амьдрах зэрэг нь эрэгтэйчүүдэд илүү ачаалалтай байдаг. Малгүй болсон иргэд аймгийн төв орж ирсэн ч ажлын байр байхгүйн улмаас ядуучуудын тоог нэмэгдүүлэх хандлагатай байна (Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөлтийн процессыг боловсронгуй болгох үндэсний чадавх бэхжүүлэх төсөл, 2021). Хөдөө орон нутгаас хот суурин газар руу чиглэсэн уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан хүн амын шилжилт хөдөлгөөн нэмэгдэж, малчид

ядуурал өртөх магадлал их байна. Байгалийн гамшигт үзэгдлийн үед нийгмийн эмзэг бүлгийн өрхийн гишүүд хүчирхийлэлд өртөмтгий байдаг учраас тэднийг хамгаалах асуудлыг дэлхийн дахинд чухалчлан авч үздэг.

Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэрлэх, даван туулах, бууруулах чиглэлд олон улсын болон улс орны түвшинд анхаарлаа хандуулан холбогдох баримт бичгүүдийг баглан хэрэгжилтийг хангахад ихээхэн хүчин чармайлтыг гаргаж байна. Тухайлбал, НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Суурь Конвенц (**НҮБ УАӨСК**), НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх “Талуудын Бага Хурал” буюу “**ТБХ/СОР**”, Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах “**Парисын хэлэлцээр**”, Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын конвенц, **Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний төлөвлөгөө** (УАӨДЗТ/НАР), НҮБ-ын УАӨСК-д зааснаар улс орон бүр хүлэмжийн хийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмэр (ҮТХН), Улс орнууд Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах урт хугацааны хөгжлийн стратеги (LT-LEDS), Жендэрийн талаар Тогтвортой Хөгжлийн Зорилт 5 (ТХЗ 5), уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах Тогтвортой Хөгжлийн Зорилт 13 (ТХЗ 13), хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх Тогтвортой Хөгжлийн Зорилт 17 (ТХЗ 17), Хөдөөгийн эмэгтэйчүүд, охидын аж байдлыг сайжруулах тухай НҮБ-ын тогтоол, Улаанбаатар тунхаглал, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги (2022-2031) зэрэг болно.

Жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх малчдын ойлголт, хандлага

Судалгаа нь феминист онол болон жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалд суурилсан. Феминист онолоор эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хэн хэнд тодорхой үүрэг хариуцлага ноогдуулан хэм хэмжээ, хязгаарлалт тогтоож буй жендэрийн харилцаа, эрэгтэй эмэгтэй хүний эрх мэдлийн зөрүүтэй байдал, аливаа шударга бус хандах, шударга бус байдлыг зөвтгөх үндэс болдог жендэрийн хэвшмэл үзлийг ЖСХ-ийн суурь шалтгаан гэж үздэг (ЖҮХ, 2018). Аливаа хүчирхийллийн хэлбэр нь эмэгтэйчүүдийн эрх мэдлийг хязгаарлах замаар бие даасан байдлыг сулруулдаг. Жендэрийн тэгш байдал нь тухайн нийгэмд тодорхой үнэ цэнэ бүхий бүтээгдэхүүн, боломж, нөөц, урамшууллыг эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эдлэх эрхтэйг илэрхийлдэг, өөрөөр хэлбэл, хүнд хүйсийн ялгаваргүйгээр эдгээрийг эдлэх бололцоо, хүртэх боломж нь тэгш байх явдал юм. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс нийгэмдээ болон хувийн амьдралын хүрээндээ эн тэгш үнэлэгдэж, тэгш эрх мэдэл, оролцоотой байх, нөхцөл байдлыг адил тэгш болгоход анхаарах нь чухал. Жендэрийн тэгш байдлыг бий болгох нь нийгмийн хөгжил дэвшилд түлхэц болох, хүн амын тодорхой бүлэгт байгаа шударга бус байдал, түүний аливаа ялгаварлал, хязгаарлалтыг арилгах арга замыг оновчтой болгох явдал юм. Монгол улсын хүн амын 10 гаруй хувийг (ҮСХ-ны 2024 оны байдлаар 308730 малчид) эзэлдэг малчид (ҮСХ, 2024) нь байгалийн гамшигт үзэгдлийн үед ялгаварлан гадуурхалт, хязгаарлалтад өртөж, улмаар ЖСХ нэмэгддэг байна.

Судалгааны ажлын хүрээнд үндсэн ойлголтуудыг дараах байдлаар авч үзсэн.

- "жендэрийн эрх тэгш байдал" гэж эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг (ЖЭТБХТХ-ийн 4.1.2).
- “зуд” гэж өвөл, хаврын улиралд цаг агаар хүндэрснээс мал сүрэг бэлчээр, усаар нэн гачигдаж, турж зутран олноор хорогдох нөхцөл бүрдэхийг (MNS 6010:2016 Гамшгийн холбогдолтой нэр томъёо, тодорхойлолт, х.6);

- “жендэрт суурилсан хүчирхийлэл” гэж жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, эс үйлдэхүй (ЖЭТБХТХ-ийн 4.1.8).

Энэхүү судалгаагаар малчдын жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх ойлголт, хандлага, зудын

үеийн малчид жендэрт суурилсан хүчирхийллийн ямар хэлбэрүүдэд өртөж буйг тодруулахыг зорьсон. Судалгааны мэдээллийг тоон болон чанарын судалгааны арга зүйд суурилсан бөгөөд Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Увс, Завхан, Хэнтий, Хөвсгөл аймгийн зудад өртсөн нийт 3665 өрхөөс 382 өрхийг түүвэрлэн судалгааг гүйцэтгэсэн.

Хүснэгт 1. Түүврийн хүснэгт

№	Аргууд	Түүврийн хэмжээ	Мэдээлэл цуглуулалтын арга
1	Асуулга	382	Биечлэн болон утсаар
2	Фокус бүлгийн хэлэлцүүлэг	3	Биечлэн

Эдгээрээс гадна, үндэсний болон орон нутгийн хууль, эрх зүйн зохицуулалт, хийгдсэн ажлуудтай холбоотой баримт бичгүүдтэй танилцсан.

Судалгаанд хамрагдсан малчдын дундаж нас нь 46 байсан бөгөөд үүнээс эрэгтэйчүүдийнх 47, эмэгтэйчүүдийнх 45 байлаа. Оролцогчдын 18 хүртэлх хувь нь 24 хүртэлх, 27 хувь нь 35-44, 29 хувь нь 45-54, 25 хувь нь 55-аас дээш насныхан байв. Судалгаанд бүх насны бүлгийн төлөөллийг хамруулсан бөгөөд тус бүрийн хүйсийн харьцаа ойролцоо буюу мэдэгдэхүйц ялгаагүй байна. Хүйсийн хувьд ялгаа төдийлөн ажиглагдахгүй байгаа ч, ахимаг насны малчид арай илүү хувийг эзэлж байна. Мөн, малчдын ихэнх нь бүрэн дунд, түүнээс доош боловсролтой байв. Боловсролын түвшнийг хүйсээр харвал, дээд болон бүрэн дунд боловсролтой эмэгтэй малчдын эзлэх хувь нь эрэгтэйчүүдтэй харьцуулахад 3-4 хувиар илүү байна.

Үнэлгээнд оролцогчдын өрхийн шинж байдлыг харвал, 382 малчин өрхөд нийт 1626 өрхийн гишүүд, дунджаар нэг малчин өрхөд 4-5 хүн амьдарч байна. Үүнээс, 47 хувь нь эрэгтэйчүүд, 53 хувь нь эмэгтэйчүүд байна. Нийт 382 малчин өрхийн 6-7 өрх тутмын нэгд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн эсхүл өрх толгойлсон хүн амьдарч байна.

График 1. Өрхийн бүтэц



Өрхийн гишүүдийн зуршлыг харахад, өрхийн гишүүдийн дунд тамхи хэрэглэдэг гишүүд нэлээд байна. Мөн нийт өрхийн 14 хувь нь архи, согтууруулах ундааны хэрэглээтэй гишүүд байв. Ялангуяа, эдгээр архи, согтууруулах ундаа хэрэглэж буй гишүүдийн олонх нь заримдаа, 9.4 хувь нь ихэвчлэн, байнга,

30.2 хувь нь ховорхон хэрэглэж байна. Мөн зайн хувьд, үнэлгээнд хамрагдсан малчин өрхүүдийн өвөлжөө (37.59 км), хаваржаа (36.34 км), намаржаа (32.99 км), зунжаа (45.66 км) нь аймгийн төвөөс ойролцоогоор 30-40 км-ийн зайд байршиж байна.

Ижил төстэй судалгааны үр дүнгээс үзэхэд ЖСХ-ийн талаар ойлголт, мэдлэг тааруу, хангалтгүй байх тусам энэ төрлийн хүчирхийлэлд өртөх эрсдэл нэмэгддэг. Малчдын ЖСХ-ийн талаарх ойлголт, мэдлэгийг судалгааны ажлын хүрээнд судалж үзлээ. ЖСХ-ийн талаар үнэлгээнд хамрагдсан нийт 382 малчдын 40 гаруй хувь нь огт мэдэхгүй байна. Малчдын ЖСХ-ийн талаарх ойлголтын хувийг тооцон гаргахдаа индексжүүлэх шинжилгээг хийж, индекс утгыг бодохдоо огт мэдэхгүй, сонсож байгаагүй эсвэл зөвхөн л сонсож байсан гэсэн хариулт өгсөн бол 'мэдэхгүй', харин ерөнхий ойлголттой эсвэл маш сайн мэднэ гэсэн хариултыг сонгосон бол 'мэднэ' ангилалд оруулав. Үнэлгээнд хамрагдсан малчдын 79.8 хувь нь ЖСХ-ийн талаар мэдэхгүй, харин 77 буюу 20.2 хувь нь мэднэ гэсэн үр дүн гарлаа. ЖСХ-ийн талаар 4 малчин тутмын гурав нь ойлголтгүй байгааг цаашид анхаарч, ойлголтыг нэмэгдүүлэх арга хэмжээг онцлогт тохируулан хүргэх нь чухал байна. Судалгааны үр дүнгээс харахад, малчид нь ЖСХ-ийн хэлбэрүүдээс гэр бүлийн хүчирхийллийн хэлбэрийг голчлон мэдэж байгаа бөгөөд гэр бүлийн хүчирхийллийн 3-4 хэлбэрийг нэрлэж байв. Аймгаар нь харьцуулан үзэхэд малчдын ЖСХ-ийн талаарх ойлголт, мэдлэгт эрс ялгаатай байдал ажиглагдаагүй ч Увс, Ховд аймгуудын малчдын мэдлэг бусад аймагтай харьцуулахад сайн, харин Хэнтий, Говь-Алтай аймгийн хувьд мэдлэг тааруу байв. Насны хувьд, нас ахих тусам малчдын ЖСХ-ийн талаарх ойлголт дутмаг байна.

Эрэгтэй малчдын хол зорчих үедээ эхнэр/хамтран амьдрагчаасаа зөвшөөрөл авч байгаа хувь нь эмэгтэйчүүдтэй харьцуулахад 2 дахин их байгаа ч, шаардлагагүй үед нөхөр/хамтран амьдрагч нь заавал хамт явдаг гэж хариулсан хувь эмэгтэйчүүдийн дунд өндөр байна. Харин үнэлгээнд хамрагдсан эрэгтэйчүүдийн 23.8 хувь нь эхнэрээсээ, харин эмэгтэйчүүдийн 12.7 хувь нөхрөөсөө зөвшөөрөл авч хол газар зорчдог гэжээ. Нийт малчдын дунд хувийн асуудлаар хол зорчих хэрэгцээ гарвал 70.9 хувь нь эхнэр/нөхөртэйгөө харилцан ярилцаж ард үлдэж буй ажлаа хуваарилдаг байна.

Орон нутагт ЖСХ-д өртөх эрсдэлд орсон эсвэл өртсөн тохиолдолд хандах үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын талаар хэр мэдлэгтэй болохыг тодруулан судлав. Малчдын хувьд эдгээр байгууллагуудыг огт сонсож байгаагүй хувь өндөр байгаа бөгөөд тухайлбал, тусламжийн утсыг (102, 107, 108) 22.5 хувь нь, нийгмийн ажилтныг 18.8 хувь, хамтарсан багийг 34.8 хувь нь, хамгаалах байрыг 57.3 хувь нь, сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр зөвлөгөө өгөх 1800-2000 утсыг 74.1 хувь нь огт сонсож байгаагүй гэжээ. Малчдын ЖСХ-д өртөх эрсдэлд орсон эсвэл өртсөн тохиолдолд тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудыг мэддэг эсэх хувийг индексжүүлэх шинжилгээ хийсэн. Улмаар, огт сонсож байгаагүй, сонсож байсан ч сайн мэдэхгүй гэсэн хариултаудыг өгсөн бол 'мэдэхгүй', харин сонсож байсан, сайн мэднэ ба үйлчилгээ авч байсан гэсэн хариултыг сонгосон бол 'мэднэ' гэсэн индекс утгыг өгч тооцов. Индексжүүлэх шинжилгээний үр дүнгээр нийт малчдын 32.7 хувь нь байгууллагуудын талаар тодорхой хэмжээнд мэдэж байна. Эдгээр үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын талаарх малчдын мэдлэгийг байршлаар нь судлан үзвэл Говь-Алтай, Увс аймгуудын малчдын мэддэг гэж хариулсан хувь нь бусад аймгуудтай харьцуулахад илүү байв. Хүйсээр нь шинжилбэл нийгмийн ажилтан, хамтарсан баг, хамгаалах байрны талаар мэддэг гэж хариулсан эмэгтэйчүүдийн хариултын хувь эрэгтэйчүүдийнхтэй харьцуулахад 4 хувиар илүү, харин тусламжийн утас (102, 107, 108) болон сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр зөвлөгөө өгөх 1800-2000 утсыг мэддэг гэж хариулсан эрэгтэйчүүдийн хувь эмэгтэйчүүдийнхтэй харьцуулахад 3 хувиар илүү байв.

Малчдын 8.1 хувь нь буюу 31 малчин (давхардсан тоогоор) ЖСХ болон түүний төрөл дотроос ялангуяа гэр бүлийн хүчирхийлэл болон хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн үедээ

байгууллагуудын тусламж, үйлчилгээг авч байжээ. Хүйсээр нь харьцуулан харвал, 21 малчин (67.7%) нь эмэгтэй, 10 малчин (32.3%) нь эрэгтэй байна.

Фокус бүлгийн ярилцлагаар нэг малчин зудын үеэр хөрш айлын эмэгтэй өдөр бүр нөхрийнхөө дарамтад байгааг мэдэн цагдаад хандахыг зөвлөж байжээ.

Зудын үед жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн байдал

Шигтгээ 1. Баян-Өлгий аймаг, Бүлгийн ярилцлага

... Манай хөрш айлын эхнэр байнга дарамтад байдаг байсан. Нөхөр нь орой болгон уурлаад загнаад байдаг хааяа гар хүрдэг асуудалтай байсан. Хэд хэдэн удаа ийм асуудал гарсан болохоор би нэг өдөр уулзах гэж очоод нууцаар эхнэрт нь эмэгтэйчүүдийг хамгаалдаг холбоо гэж байдаг хууль дүрэм гэж байдаг цагдаад хэл тусламж хүс багийн даргатай ярь гэж ятгасаар байгаад цагдаа нарт холбож өгсөн. Үүнээс хойш сүүлд нэг уулзахад та үнэхээр их тус болсон эгч ийм юм байдаг талаар би мэддэггүй байж гээд хөөрхий үйлж байсан юм. Тухайн үед сэтгэл санаагаар унаад хүмүүстэй ярилцахгүй чимээгүй хүн байдаг байсан бол одоо овоо гайгүй инээгээд л хүмүүстэй ярилцаад сайхан амьдарч байгаа юм шиг санагддаг юм.

Зудын үеэр нийт малчдын 15.9 хувь буюу 61 малчин ямар нэгэн сэтгэл зүйн ачаалал, дарамт, хүчирхийлэлд өртсөн ба ялангуяа гэр бүлийн хэн нэгэн гишүүн уурлах, зэмлэх үзэгдэл хамгийн их буюу жирийн үетэй харьцуулахад 3 дахин их гарчээ. Зудын үеэр эрэгтэйчүүдийн 15.0 хувь, эмэгтэйчүүдийн 11.1 хувь нь зэмлэсэн, айлгасан, сүрдүүлсэн зэрэг сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн тухайгаа хуваалцжээ. Мөн хэн нэгэн хүсээгүй үед нь биед нь хүрэх тохиолдол (1.6%) гарсан бөгөөд түүнд зөвхөн зөвхөн 36-55 насны 3 эрэгтэй өртжээ. Хүсээгүй үед биед нь хүрсэн 3 тохиолдлын 2 нь сумын төв дэх олон нийтийн газарт, нэг нь тодорхой бус газар тохиолджээ. Эдгээрээс 2 тохиолдол нь зудын үед шинээр гарсан, 1 тохиолдол нь заримдаа давтан гардаг тохиолдол байна. Энэхүү тохиолдлын талаар хэн нэгэнтэй хуваалцаагүй, учир нь сумынхан буруугаар ойлгож, муугаар хэлэх учраас гэж мэдэгджээ. Харин айлгасан, сүрдүүлсэн тохиолдол (2.6%) хүйсээс үл хамааран адилхан гарчээ.

Эдгээр хүчирхийллийг хаана гарсан байршлаар нь судалж үзвэл гэр бүлийн хэн нэгэн гишүүн уурлах, зэмлэх үзэгдэл нь голдуу гэрт (n=22), малын хашаа хороонд (n=7), хөдөө хээр, малын бэлчээрт (n=5) болон сумын төв дэх бусад олон нийтийн газар (n=5) тохиолдсон. Харин хэн нэгэн айлган сүрдүүлсэн үзэгдэл нь гэрт (n=3), сумын төв дэх бусад олон нийтийн газар (n=3) болон хөдөө хээр, малын бэлчээрт (n=2) гарчээ. Эдгээр үзэгдлүүд нь зуд тохиолдоход илүү их гарсан болохыг баталсан. Хүйсийн хувьд эрэгтэйчүүдэд гэр бүлийн хэн нэгэн гишүүн уурлах, зэмлэх үйлдлийг илүү гаргахын сацуу хэн нэгэн өөрийн хүсээгүй үед биед нь хүрсэн асуудал гарчээ.

Зудын үеэр аль нэг төрлийн хүчирхийлэлд өртсөн 61 малчнаас 46 хувь нь буюу 28 малчин нь өөрт тохиолдсон зүйлээ хэн нэгэнтэй хуваалцжээ. Харин өөрт тохиолдсон зүйлээ хуваалцсан малчдын хувьд, голдуу гэр бүл, хамаатан садантайгаа, цөөхөн тохиолдолд найз нөхөд, хөршүүдтэйгээ хуваалцсан байна.

Эмэгтэйчүүд ихэвчлэн гэр бүл хамаатан, садандаа, харин эрэгтэйчүүд найз нөхөд хөршүүдтэйгээ хуваалцсан байна. Харин бусдад мэдэгдээгүй 33 малчдын 54.5 хувь нь гэр бүл дотроо ярилцаад шийдэж болох учраас, 21.2 хувь нь асуудал шийдэгдэхгүй учраас хэн нэгэнд хандах шаардлагагүй гэж үзжээ.

Малчдаас тэдний ойр орчинд бусад хүмүүс гэр бүлийн аюулгүй, амгалан тайван байдлыг алдагдуулах тохиолдол гардаг эсэхийг тодруулахад өрхөд нь (3.98), саахалт айлд (3.86), ойр орчмын нутгийнханд (3.79), сумынханд (3.77) огт тохиолддоггүй гэж хариулсан. Мэдээлэлд индексжүүлэх шинжилгээг хийж,

индекс утга нийтлэг, заримдаа гэсэн хариулт бол аюултай, харин ховор, огт үгүй, мэдэхгүй гэсэн хариултыг сонгосон бол аюулгүй гэж үзэв. Малчдын зөвхөн 15.2 хувь нь сумынхан, харин 10.2%~10.7% нь саахалт айл болон ойр орчмын нутгийнхан гэр бүлийнхэн аюулгүй, амгалан тайван байдлыг алдагдуулах тохиолдол гаргадаг гэж үзжээ.

Зудын үеэр ЖСХ-д өртсөн хохирогч/даван туулагчдыг хамгаалах механизм, тэдэнд үзүүлэх үйлчилгээг үзүүлэх боломж байдаг эсэхийг судалгаанд оролцогчдоос тодруулахад 7 аймгийн 14 сумын иргэд дараах байдлаар хариулжээ.

- ЖСХ-д өртсөн тохиолдолд хаана хандахыг ‘мэдэхгүй’ гэж бүлгийн ярилцлагад оролцсон малчдын ихэнх нь хариулж байхад ганцаарчилсан ярилцлагад хамрагдсан төрийн албан хаагчдын хувьд хохирогч/даван туулагчийг хамгаалах, хамгаалалтын механизм хангалтгүй ажилладаг гэв. Гэхдээ ЖСХ-ийн нэг төрөл болох гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдыг хамтарсан баг, цагдаагийн байгууллагад ханддаг.
- Бүлгийн ярилцлагад оролцогчдын хувьд зудын үеэр ЖСХ-д өртсөн хохирогч/даван туулагчдад ямар төрлийн үйлчилгээнд хамрагдах боломжтой талаарх мэдээлэлгүй байна. Байгалийн гамшигт үзэгдэл болох үед гэр бүлийн харилцаанд асуудал үүсдэг. Багадаа л үл ойлголцох, маргалдах зөрчил байдаг. Гэхдээ бусдаас дэмжлэг авч байсан туршлага бага байдаг. Гэр бүл дотроо ихэвчлэн шийдвэрлэдэг гэжээ.
- Ганцаарчилсан ярилцлагад оролцогчдын хувьд хохирогч илэрсэн тохиолдолд аюулгүй байдлыг хангах үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ буюу хүнсний эрхийн бичиг олгох, хувийн хэвшлээс өгсөн хоол хүнсний туслалцааг үзүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах зэргээр арга хэмжээ авдаг тухай дурдаж байв.

Шигтгээ 2. Хэнтий аймаг, Бүлгийн ярилцлага

Энэ жилийн хаврын зуд бол ёстой хэцүүхэн байсан. Бүх малыг хашиж хашаандаа байлгах тэжээл тавьж өгөхөд нэг хүний хүч хүрэхгүй нь тодорхой. Би гэртээ нялх хүүхдээ харна. Нөхөр орж ирээд уцаарлана. Би ч өөдөөс нь дуугүй байхгүй. Үл ойлголцол үүсэхийн хувьд үүссэн. Ядарсан үедээ уураа надад гаргах үе байсан.

Гамшигт үзэгдэл болоход ЖСХ, түүний төрөл хэлбэрүүд болох гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, дарамт зэргийн эрсдэл нэмэгдэх хандлагатай байдаг. Судалгаанд оролцогчдын ярилцлагын үр дүнгээс дүгнэхэд ЖСХ нь аймгийн төв, сумын төв, хөдөө нутагт амьдарч байгаа иргэдэд харилцан адилгүй байдлаар илэрдэг байна. Тухайлбал,

- Аймгийн төв болон сумын төвүүдэд амьдарч байгаа хүмүүс гэртээ байдаг. Ачаалал бага. Тэжээвэр мал байвал өвс тэжээл өгөх ажил хийнэ.
- Малчин өрхийн хувьд нялх хүүхэдтэй, хүн хүч багатай үед бие биедээ уурлах, уцаарлах, маргалдах, үл ойлголцох тохиолдол элбэг байдаг. Гэрийн эзэн ганцаараа бүх ажлыг хийж амжихгүй. Тиймээс уурлах, бухимдах асуудал байдаг.

Судалгаанд оролцогчдын хувьд зудын үеэр сэтгэл зүйн хямралд өртөх, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ авах хэрэгцээ байдаг. Орон нутагт мэргэжлийн сэтгэл зүйч байдаггүй болохоор тэгээд л өөрсдөө гэр бүл дотроо л шийддэг тухай нийтлэг дурджээ.

Хэрвээ малчны ойрын харилцаа, холбоотой хүн түүний аюулгүй, амгалан байдлыг удаа дараа алдагдуулбал малчдын 38.2 хувь нь буюу 146 малчин нь өөрөө өөрийгөө хамгаалаад тухайн нөхцөл байдалд зохицоод үлдэнэ гэсэн бол 89 буюу 23.3 хувь нь албан тусламж, дэмжлэг авдаг (цагдаа, шүүх) гэсэн хариултыг өгсөн. Энэ нь холбогдох байгууллагуудад хандахаас илүүтэйгээр өөрсдөө шийдвэрлэх хандлага байгааг харуулж байгаа юм. Үүнд, хүйсийн хувьд мэдэгдэхүйц ялгаа ажиглагдахгүй байна.

График 2. Аюултай нөхцөл байдалд авах арга хэмжээ, хүйсээр



Аймгаар нь шинжилж үзвэл Хэнтий аймгийн малчдын ихэнх нь цагдаа, шүүхийн байгууллагаас тусламж, дэмжлэг авдаг бол Говь-Алтай, Ховд, Увс аймгуудын малчид ихэвчлэн өөрөө, өөрийгөө хамгаалаад тухайн нөхцөл байдалд зохицоод үлдэнэ гэжээ.

Судалгааны үр дүнгээр давхардсан тоогоор 74 малчин өөрийгөө хамгаалуулахаар цагдаа, эмнэлэг, ОУБ, малчдын бүлэг, хоршооны гишүүддээ, түүнчлэн ТББ, шүүхэд хандсан бөгөөд 29 малчин цагдаад, 24 малчин эмнэлэгт, 17 малчин ОУБ-д тусламж дэмжлэг хүсэж байжээ. Малчид цагдаад голдуу гэр бүлийн хүчирхийлэл, малын хулгайгаар, харин эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх, үзлэгт хамрагдахаар хандсан. Малчид ОУБ-д нэн хэрэгцээтэй хүнс, өвс гэжээлийн асуудлаар ханджээ. Малчдын асуудлыг шийдвэрлэхэд орон нутгийн эсвэл мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ТББ, малчдын бүлэг, хоршоог идэвхтэй татан оролцуулах нь зүйтэй. Эдгээр үйл ажиллагааг сум, орон нутгийн захиргаа дэмждэг, урамшуулдаг, сайн туршлагын түгээн дэлгэрүүлэх байдлаар хамтран ажиллаж болох юм.

Дүгнэлт

Малчдыг нийтэд нь харахад, голдуу ахимаг насныхан ихэнх хувийг эзэлж байна. Боловсролын түвшний хувьд, ихэнх (92%) нь бүрэн дунд, түүнээс доош боловсролтой байна. Нэг малчин өрх айлд дунджаар 4-5 хүн амьдарч байна.

Зудад өртсөн малчдаас ЖСХ-ийн талаарх ойлголт, хандлагыг тодруулахад олонх нь (79.8%) огт мэдэхгүй, сонсож байгаагүй, зөвхөн сонсож байсан гэсэн хариултыг өгчээ. Ер нь энэ талаарх ойлголт, мэдлэг хангалтгүй, ялангуяа боловсрол багатай, 45-аас дээш насны эрэгтэйчүүдийн дунд түгээмэл байна. ЖСХ-ийн хохирогч/даван туулагч болоход гэр бүлийн таагүй уур амьсгал, аль нэг гишүүн нь архины хамааралтай байх, хүчирхийлэл, дарамттай байх, салалт зэрэг гэр бүлийн хүчин зүйлс нөлөөлдөг гэж малчдын 51 хувь нь үзсэн байхад, амьжиргааны түвшин доогуур, ажилгүйдэл, ядуурал, бага орлого, үнэлгээгүй хөдөлмөр нөлөөлж байна гэж 32 хувь нь үзсэн. Мөн, 38.2 хувь нь ойрын харилцаа холбоотой хүн аюулгүй, амгалан байдлыг алдагдуулсан тохиолдолд өөрийгөө хамгаалаад, тухайн нөхцөл байдалд зохицоод үлдэнэ гэж хариулсан нь тэдний дунд аюул, эрсдэлт нөхцөл байдал нуугдмал, дарагдаж үлдэх магадлалтай болохыг харуулж байна.

Зудын үеэр малчдын сэтгэл зүй, бие махбод, санхүү болон бусад суурь хэрэгцээнд нь сөрөг нөлөө үүсэж байна. Тэдний сэтгэл зүйн байдлыг тандвал, 13.6 хувь нь айдас түгшүүртэй, 15.9 хувь буюу 61 малчин сэтгэл санаа, бие махбодын хүчирхийлэлд өртсөн нь гамшгийн бус үетэй харьцуулахад 3 дахин их

байна. Эрэгтэй малчдын 15.0, эмэгтэйчүүдийн 11.1 хувь нь сэтгэл санааны хүчирхийлэл буюу зэмлэл, айлган сүрдүүлэгт өртжээ. Мөн, хүсээгүй үед хэн нэгэн биед нь хүрэх тохиолдол цөөн (1.6%) гарсанд зөвхөн эрэгтэйчүүд өртжээ. Энэхүү хүчирхийллийн тохиолдлын олонх буюу 62.3 хувь нь давтагдсан шинжтэй байсан бол, 37.7 хувь (n=23) нь анхных байжээ.

НОМ ЗҮЙ

Л.Даваажаргал, Б.Ананд, Э.Хосбаяр. (2023, 2 28). *Монгол банк*. Retrieved from www.mongolbank.mn:
<https://www.mongolbank.mn/mn/research/776>

Дэлхийн банк. (2024). *Уур амьсгал ба хөгжил тайлан*. Улаанбаатар хот: Дэлхийн банк групп.

ЖҮХ. (2018). *Жендэр ба бодлого төлөвлөлт*. Retrieved from <https://www.ncge.gov.mn>:
<https://www.ncge.gov.mn/wp-content/uploads/2023/12/MODUL-LAST-.pdf>

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт. (2018). *Малчдын аж байдлын судалгаа*. Retrieved from Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт:
<https://www.institute.gov.mn/storage/sudalgaas/June2024/862kaalWLkvoAPNkF1ZR.pdf>

Хүнсний хувьсгал үндэсний хөдөлгөөн. (2024, 05 24). *Хүнсний хувьсгал*. Retrieved from Мал аж ахуйн салбарын өнөөгийн байдал, цаашдын хөгжил: <https://hunsniihuvvisgal.mn/post/95732>

Ус цаг уур орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн. (2024). *Уур амьсгалын үйлчилгээний систем*. Retrieved from Уур амьсгалын үйлчилгээний систем: <http://climate-service.mn/climateservice/index.php?menuitem=14&product=>

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төлөвлөлтийн процессыг боловсронгуй болгох үндэсний чадавх бэхжүүлэх төсөл. (2021). *Жендэр болон орхигдсон бүлгүүдэд чиглэсэн эмзэг байдлын үнэлгээ*. Улаанбаатар хот: Байгаль орчин, аялал жуучлалын яам, Уур амьсгалын ногоон сан.

ҮСХ. (2024). *Статистикийн мэдээллийн нэгдсэн сан*. Retrieved from https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1001_022V1&BAG_select_all=0&BAGSingleSelect=_0&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2024&viewtype=table:
<https://www2.1212.mn> Ministry of Environment and Tourism of Mongolia, GEF and UNEP. (April, 2024). *Fourth National Communication of Mongolia*. Ulaanbaatar: Ministry of Environment and Tourism of Mongolia.

University of Notre Dame. (2023). *Rank countries by ND-GAIN Country Index, Vulnerability and Readiness*. Retrieved from <https://gain.nd.edu>: <https://gain.nd.edu/our-work/country-index/rankings/>

USAID. (2017). *МУ-ын уур амьсгалын эрсдэлийн танилцуулга*. Retrieved from <https://www.climatelinks.org>:
https://www.climatelinks.org/sites/default/files/asset/document/2017_USAID%20ATLAS_Climate%20Risk%20Profile%20-%20Mongolia.pdf